

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн
төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/23-НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Гэрээт аудитор: Г.Сампилмаа Утас: 261628 Цахим хаяг: Sampilmaag@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ий захирал Ж.Баяртуул Утас: 99066015 Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/360
танай _____-ны № _____-т

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ
ХАМГААЛАХ ХОЁР ҮЕ ШАТТАЙ
ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ж.ТҮВШИНТӨГС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 1 дүгээр үе шат 2006-2010 онд, 2 дугаар үе шат 2011-2015 оны хооронд амжилттай хэрэгжсэн. Төслийн зээлийн үндсэн эх үүсвэр 2015 онд бүрэн олгож дууссанаас хойш төслийн хэрэгжилт эргэн төлөлтийн сангийн эх үүсвэрээр тогтвортой хэвийн үргэлжилж, тайлант хугацаанд хуваарийн дагуу төслийн зээлийн эргэн төлөлт гэрээт арилжааны банкнуудаас бүрэн төлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зээлийн эргэн төлөлтөөс жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр 35 аж ахуйн нэгжид 12,961,930.0 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 2 аж ахуйн нэгжид 895,000.0 мянган төгрөг, нийт 13,856,930.0 мянган төгрөгийн зээлийг олгосноор тайлант онд 515 ажлын байр шинээр бий болгосон байна.

Бусад асуудал

Аудитын хугацаанд баримт материалыг саадгүй гаргаж, санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	116,798,408,120.45	112,292,021,932.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,902,984,235.34	13,370,493,544.95
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	15,902,984,235.34	13,370,493,544.95
31210	Төгрөг	14,948,449,886.34	12,377,889,455.27
31211	Төрийн сангийн харилцах	49,252.95	-
31212	Монгол банкин дахь харилцах	14,948,400,633.39	12,377,889,455.27
31220	Гадаад валют	954,534,349.00	992,604,089.68
31222	Монгол банк дахь харилцах	954,534,349.00	992,604,089.68
33	АВЛАГА	88,111,419,661.07	86,138,043,518.38
33600	Зээлийн авлага	88,111,419,661.07	86,138,043,518.38
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	88,111,419,661.07	86,138,043,518.38
35	БАРАА МАТЕРИАЛ	12,784,004,224.04	12,783,484,869.04
35400	Хангамжийн материал	12,784,004,224.04	12,783,484,869.04
35410	Бичиг хэргийн материал	485,100.00	-
35440	Түлш, шатах тослох материал	76,842.00	42,587.00
35470	Бусад хангамжийн материал	12,783,442,282.04	12,783,442,282.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,047,542.97	1,759,611.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,047,542.97	1,759,611.86
39200	Биет хөрөнгө	4,047,542.97	1,759,611.86
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	34,462,345.00	34,462,345.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,474,802.03)	(32,762,733.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,779,151.51	13,779,151.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,779,151.51)	(13,779,151.51)
39217	Ном	60,000.00	60,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.00)	(880,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	116,802,455,663.42	112,293,781,544.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	137,726,801,593.30	139,020,834,221.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,000.00	9,098,720.00
41300	Өглөг	18,000.00	9,098,720.00
41360	Бусад өглөг	-	9,098,720.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	137,726,783,593.30	139,011,735,501.90
42200	Урт хугацаат зээл	137,726,783,593.30	139,011,735,501.90
42220	Гадаад валют	137,726,783,593.30	139,011,735,501.90
42224	Төслийн зээл	137,726,783,593.30	139,011,735,501.90
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(20,924,345,929.88)	(26,727,052,677.67)
51	Засгийн газрын хувь оролцоо	(20,924,345,929.88)	(26,727,052,677.67)
51200	Хуримтлагдсан үр дүн	(20,924,345,929.88)	(26,727,052,677.67)
51210	Өмнөх үеийн үр дүн	(39,232,668,072.51)	(20,924,345,929.88)
51220	Тайлант үеийн үр дүн	18,308,322,142.63	(5,802,706,747.79)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	116,802,455,663.42	112,293,781,544.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,107,823,501.59	3,038,943,370.18
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	2,643,212,625.18
110	Орлогын албан татвар	-	2,643,212,625.18
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	2,643,212,625.18
110002	Үйл ажиллагааны орлого	-	2,643,212,625.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,713,106,801.59	395,730,745.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,713,106,801.59	7,745.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,713,106,801.59	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,442.00	-
1200046	Зээлийн хүүгийн орлого	2,713,029,359.59	-
120009	Бусад орлого	-	7,745.00
122	Тусламжийн орлого	-	395,723,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	395,723,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	395,723,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	395,723,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,716,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	394,716,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	394,716,700.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,379,008,654.51	1,383,425,820.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,379,008,654.51	1,383,425,820.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,191,785.20	407,574,520.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,420,000.00	31,594,500.00
210304	Байрны түрээс	27,420,000.00	31,594,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,384,000.00	3,550,900.00
210401	Бичиг хэрэг	1,547,300.00	1,499,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,730,600.00	242,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	824,160.00	814,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,281,940.00	995,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202,860.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,860.00	-
2107	Томилолт, зочны зардал	12,514,900.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	12,514,900.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,655,687.05	362,422,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	345,655,687.05	347,564,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,760,000.00
210807	Газрын төлбөр	-	4,098,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,014,338.15	9,926,300.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,000.00	7,268,369.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,734,338.15	2,287,931.11

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

211	ХҮҮ	981,816,869.31	975,757,815.99
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	981,816,869.31	975,757,815.99
211101	Бусад гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	981,816,869.31	975,757,815.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	93,483.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	93,483.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	93,483.95
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	93,483.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	93,483.95
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,728,814,847.08	1,655,517,550.13
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	32,796,081,107.45	12,293,720,441.19
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	32,796,081,107.45	12,293,720,441.19
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,216,573,811.90	19,751,944,739.11
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,216,573,811.90	19,751,944,739.11
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	16,579,507,295.55	(7,458,224,297.92)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	18,308,322,142.63	(5,802,706,747.79)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	20,872,806,719.37	18,869,241,767.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,080,057,296.50	18,869,241,767.87
120	Нийтлэг татварын бус орлого	9,080,057,296.50	18,473,518,767.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,080,057,296.50	18,473,518,767.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,367,027,936.91	18,473,518,767.87
1200046	Зээлийн хүүгийн орлого	2,713,029,359.59	-
122	Тусламжийн орлого	-	395,723,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	395,723,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	395,723,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	395,723,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,792,749,422.87	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,792,749,422.87	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	394,716,700.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	11,398,032,722.87	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,376,484,316.36	1,371,530,068.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,376,484,316.36	1,371,530,068.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,667,447.05	395,678,769.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,420,000.00	31,594,500.00

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	27,420,000.00	31,594,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,882,000.00	2,823,800.00
210401	Бичиг хэрэг	1,335,900.00	1,014,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	824,160.00	814,200.00
210404	Ном, хэвлэл	440,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,281,940.00	995,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	202,860.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,860.00	-
2107	Томилолт, зочны зардал	16,244,900.00	280,000.00
210702	Дотоод албан томилолт	16,244,900.00	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,637,687.05	353,342,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	345,637,687.05	347,582,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,000.00	7,638,369.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,000.00	7,268,369.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	370,000.00
211	ХҮҮ	981,816,869.31	975,757,815.99
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	981,816,869.31	975,757,815.99
211101	Бусад гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	981,816,869.31	975,757,815.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	93,483.95
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	93,483.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	93,483.95
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	93,483.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	93,483.95
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,496,322,403.01	17,497,711,698.93
14	Бусад эх үүсвэр	12,352,222.87	48,669,320.99
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	12,352,222.87	48,669,320.99
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	17,029,473,800.00	20,068,272,130.00
230001	Эргэж төлөгдөх зээл	17,029,473,800.00	20,068,272,130.00
24	АВСАН БОНД, ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	6,367,027,936.91	-
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	6,367,027,936.91	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	9,684,187.38	10,599,580.31
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	9,684,187.38	10,599,580.31
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(23,393,833,701.42)	(20,030,202,389.32)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3,897,511,298.41)	(2,532,490,690.39)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,800,495,533.75	15,902,984,235.34
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,902,984,235.34	13,370,493,544.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(39,232,668,072.51)	(39,232,668,072.51)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(39,232,668,072.51)	(39,232,668,072.51)
9	Тайлант үеийн үр дүн	18,308,322,142.63	18,308,322,142.63
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(20,924,345,929.88)	(20,924,345,929.88)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(20,924,345,929.88)	(20,924,345,929.88)
19	Тайлант үеийн үр дүн	(5,802,706,747.79)	(5,802,706,747.79)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	(26,727,052,677.67)	(26,727,052,677.67)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	436,739,700.00	395,629,516.05	41,110,183.95	90.6
Татварын бус орлого	436,739,700.00	395,629,516.05	41,110,183.95	90.6
Тусламжийн орлого	436,739,700.00	395,629,516.05	41,110,183.95	90.6
Төсвөөс санхүүжих	436,739,700.00	395,629,516.05	41,110,183.95	90.6
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	(2,319,260,300.00)	8,041,266,639.00	5,722,006,339.00	(346.7)
УРСГАЛ ЗАРДАЛ	436,739,700.00	395,678,769.00	41,060,931.00	90.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,739,700.00	395,678,769.00	41,060,931.00	90.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,638,600.00	31,594,500.00	44,100.00	99.9
Байрны түрээс	31,638,600.00	31,594,500.00	44,100.00	99.9
Хангамж, бараа материалын зардал	7,656,000.00	2,823,800.00	4,832,200.00	36.9
Бичиг хэрэг	4,200,000.00	1,014,600.00	3,185,400.00	24.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,296,000.00	814,200.00	481,800.00	62.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,160,000.00	995,000.00	1,165,000.00	46.1
Томилолт, зочны зардал	11,550,000.00	280,000.00	11,270,000.00	2.4
Дотоод албан томилолт	11,550,000.00	280,000.00	11,270,000.00	2.4

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,405,100.00	353,342,100.00	17,063,000.00	95.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	363,205,100.00	347,582,100.00	15,623,000.00	95.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,200,000.00	5,760,000.00	1,440,000.00	80.0
Бараа үйлчилгээний бусад зардал	15,490,000.00	7,638,369.00	7,851,631.00	49.3
Бараа үйлчилгээний бусад зардал	15,120,000.00	7,268,369.00	7,851,631.00	48.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	370,000.00	-	100.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(2,756,000,000.00)	7,645,587,870.00	4,889,587,870.00	(277.4)
Эргэж төлөгдөх зээл	(2,756,000,000.00)	7,645,587,870.00	4,889,587,870.00	(277.4)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,756,000,000.00	(7,645,637,122.95)	(4,889,637,122.95)	(277.4)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,756,000,000.00)	7,645,637,122.95	4,889,637,122.95	(277.4)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,756,000,000.00)	7,645,637,122.95	4,889,637,122.95	(277.4)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,645,637,122.95		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл нь “эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг бий болгох, жижиг дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хувийн хэвшлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, жижиг дунд бизнес эрхлэгчид болон төсөлд оролцогч банкнуудыг чадавхжуулахад оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон . байна.

- Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус төслийн нэгжийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,508.7 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,902,984.2	13,370,493.5	(2,532,490.7)
Авлага	88,111,419.7	86,138,043.5	(1,973,376.2)
Бараа материал	12,784,004.2	12,783,484.9	(519.3)
Үндсэн хөрөнгө	4,047.6	1,759.6	(2,288.0)
Нийт хөрөнгө	116,802,455.7	112,293,781.5	(4,508,674.2)
Нийт өр төлбөр	137,726,801.6	139,020,834.2	1,294,032.6
Богино хугацаат өр төлбөр	18.0	9,098.7	9,080.7
Урт хугацаат өр төлбөр	137,726,783.6	139,011,735.5	1,284,951.9
Засгийн газрын хувь оролцоо хуримтлагдсан ашиг/алдагдал	(20,924,345.9)	(26,727,052.7)	(5,802,706.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	116,802,455.7	112,293,781.5	(4,508,674.2)

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13,370,493.5 мянган төгрөг болж 2,532,490.7 мянган төгрөгөөр буурсан нь Жайкад төлөх дамжуулан зээлийн төлбөрийг 2025 оны хуваарийн дагуу Сангийн яаманд 7,187,099.9 мянган төгрөгийг шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн;
- Авлагын дансны үлдэгдэл 86,138,043.5 мянган төгрөг болж 1,973,376.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 37 аж ахуй нэгжид 13,856,930.0 мянган төгрөгийн төслийн зээл олгож, 269 аж ахуйн нэгж байгууллагын 15,830,306.1 мянган төгрөгийн үндсэн зээлийн төлбөр барагдуулсантай холбоотой;
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 9,098.7 мянган төгрөг болж, 9,080.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдсэн гэрээний дагуу аудит баталгаажуулалтын төлбөр, газрын төлбөрийг төлөөгүйтэй холбоотой;
- Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 139,011,735.5 мянган төгрөг болж 1,284,951.9 мянган төгрөгөөр өссөн нь ханшийн зөрүү 7,496,294.0 мянган төгрөгөөс шалтгаалжээ;
- Засгийн газрын хувь оролцооны алдагдал 5,802,706.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүн алдагдалтай гарсантай холбоотой байна.

Тус төслийн нэгж 2020 онд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-тай 880.0 мянган төгрөгийн гэрээний үнийн дүнтэй нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” программыг ашиглаж байгаад Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад шилжиж салбарын хэмжээнд Хас эрин орчил ХХК-ийн 1,500.0 мянган төгрөгийн гэрээний үнийн дүнтэй нягтлан бодох бүртгэлийн “Динамик-1.0” программыг ашиглаж байгаа бөгөөд тайлант онд лицензийн төлбөрт 440.0 мянган төгрөг төлсөн байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төслийн нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 502,815.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, хүргүүлсэн төсвийн төслийн саналын дүнг 64,501.5 мянган төгрөгөөр бууруулж, 438,313.7 мянган төгрөгөөр баталсан байна. Мөн зээлийн эргэн

төлөлтөөс 27,560,000.0 төгрөгийг оруулж, 7,560,000.0 мянган төгрөгийг дамжуулан зээлийн төлбөр төлөх, 20,000,000.0 мянган төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээл олгохоор төлөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны 7 дугаар сард батлагдсан төсвийг 1,944.0 мянган төгрөгөөр бууруулж 436,369.7 мянган төгрөгөөр тодотгож хуваарилсан байна.

Тус төслийн нэгжийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 436,369.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоос 6,804,000.0 мянган төгрөгийг дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс, 18,000,000.0 мянган төгрөгийг төслийн зээл олгоход тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 395,723.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, 395,678.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж, үлдэгдэл 44.2 мянган төгрөг болон оны эхний үлдэгдэл 49.3 мянган төгрөг, нийт 93.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Дамжуулан зээлийн эргэн төлөлтөөс 18,511,588.4 мянган төгрөг бүрдүүлж, 37 аж ахуй нэгжид 13,856,930.0 мянган төгрөгийн зээл олгон, дамжуулан зээлийн үндсэн төлбөрт 6,211,342.1 мянган төгрөг, хүүгийн төлбөрт 975,757.8 мянган төгрөг, нийт 7,187,099.9 мянган төгрөг төлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Биелэлт хувь
	70805-Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	25,199,723.0	20,463,950.9	(4,735,772.1)	81.2
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	395,723.0	395,678.8	(44.2)	99.9
2	81404-Дамжуулан зээлдүүлсэн зээл	6,804,000.0	6,211,342.1	(592,657.9)	91.3
3	81405-Дотоод эх үүсвэрээс олгох зээл	18,000,000.0	13,856,930.0	(4,143,070.0)	76.9

Тайлант онд тус төслийн нэгжийн орон тоог гэрээт ажилтан 6 байхаар баталж, 303,162.8 мянган төгрөгийн цалингийн зардал төсөвлөгдсөн байна. Гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 5, нийт 6 албан хаагчтайгаар 303,162.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас зарцуулсан байна.

Тайлант онд тус төслийн нэгж нь банкнуудын эдийн засагч нарт төслийн үйл ажиллагааны төсвийн талаар сургалт хийж 2,268.4 мянган төгрөг, гадаадын зээл тусламжийн талаарх Эвентийн заалны түрээсэнд 5,000.0 мянган төгрөг семинар, хурал, зөвлөгөөний зардалд 7,268.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл нь 2006 оноос хэрэгжсэн ба ЖАЙКА болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан MON-P7, MON-P9 зээлийн хэлэлцээрийн хүрээнд олгосон нийт 7,981,000.0 мянган иенийг зарцуулж дууссан ч зээлийн эргэн төлөлтөөр дахин санхүүжүүлэх замаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

Тайланд онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвсөний дагуу 5 удаагийн төслийн удирдах хорооны хурлын шийдвэрээр нийт 37 аж ахуй нэгжид 13,856,930.0 мянган төгрөгийн зээл олгож, гүйцэтгэл 76.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Зорилт 1: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бүрэлдэхүүн ий хүрээнд:	2006-2026	Санхүүжигдсэн төслийн зээлийн тоо 170 ба түүнээс дээш байх	Төсөл хэрэгжсэнээс хойш өссөн дүнгээр нийт 943 төслийг санхүүжүүлснээс Тайлант онд 35 дэд төслийг зээлийн эргэн төлөлтийн сангаас санхүүжүүлсэн байна.	18,000,000.0	12,961,930.0
			Санхүүжигдсэн төслийн мөнгөн дүн (ам.доллар) 55 сая ба түүнээс дээш байх	Төсөл хэрэгжсэнээс хойш өссөн дүнгээр нийт 396 тэрбум төгрөг буюу 113 сая ам.доллар санхүүжүүлснээс Тайлант онд 35 дэд төсөлд 12,961,930.0 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтийн сангаас санхүүжүүлсэн байна.		
			Төслийн хүрээнд нэмэгдсэн ажлын байрны тоо төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр өссөн байх	Төсөл хэрэгжсэнээс хойш өссөн дүнгээр нийт 28,437 ажлын байр бий болсноос тайлант онд 515 ажлын байр шинээр бий болсон байна.		
2	Зорилт 2: Байгаль орчныг хамгаалах бүрэлдэхүүн ий хүрээнд:	2006-2026	Байгаль орчны төслийн хувьд нүүрсний хэмжээний бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах	Төсөл хэрэгжих хугацаанд нийт 115 дэд төслийг 13.8 сая ам.доллар буюу 43.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлснээс тайлант онд 2 дэд төслийг 895,000.0 мянган төгрөгөөр эргэн төлөлтийн сангаас санхүүжүүлсэн байна. Эдгээр дэд		895,000.0

			төслүүдийн хэрэгжилтийн хүрээнд түүхий нүүрсний хэрэглээг жилдээ 118,006.82 тонноор буурсан байна. Энэ нь төсөл хэрэгжүүлэхээс өмнөх үетэй нь харьцуулахад даруй 61,675.07 тонноор бага байна.	
		Байгаль орчны төслийн хувьд нүүрсхүчлийн хийн (CO ₂) бууралт (тнн/жил) төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад тодорхой хэмжээгээр буурах	Төсөл хэрэгжсэнээр нүүрсхүчлийн хийн ялгаруулалт жилд 320,077.42 тонноор буурсан байна. Төсөл хэрэгжүүлэхээс өмнөх үетэй харьцуулахад 134,595.66 тонноор буурсан байна.	
		Байгаль орчны төслийн хувьд NO _x , CO, SO ₂ -н ялгарлын бууралт (тнн/жил)	Төсөл хэрэгжсэнээр азотын хийн хэмжээ жилдээ 584.52 тонн, хүхрийн хийн хэмжээ 422.19 тонн, тоосонцорын хэмжээ 12,697.69 тонн жингээр тус тус буурсан байна гэж үзэж хяналт шинжилгээний үнэлгээгээр 85 хувийн үр нөлөөтэй гэж дүгнэсэн байна.	

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд гэрээ шууд байгуулах худалдан авалтын аргыг ашиглан хөрөнгө, бараа материал худалдан авалтад 19,924.0 мянган төгрөг баталсан ба 9,278.0 мянган төгрөгийг зарцуулж, 46.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажлууд хэрэгжээгүй нь тайлант онд үйл ажиллагааны зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Платиниум прогресс Аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Н.Номин-Эрдэнэ, Э.Туяасайхан нар гүйцэтгэж, компаний захирал Ж.Баяртуул анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын гэрээт аудитор Г.Сампилмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 17,595,582.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 175,955.8 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагчийн төсвийн хэмнэлт, зарцуулалтад хяналт тавьж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хэрэгжилтэд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, үнэлгээ хийж ажилласан байна. Мөн аудитаар хуулийн хэрэгжилттэй хүрээнд хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт мэдээллэх 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаандаа мэдээлж, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Шилэн дансанд мэдээлсэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний орлого, зарлагын дүнтэй тулган шалгахад тохирч байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хугацаанд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэж, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж болон бусад шийдэл гараагүй байна

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдах алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар нийт 250.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөвлөмж хүргүүлэв. .

Аудитаар илрүүлсэн санхүүгийн тайлагнал, худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 250.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 175,667.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд шилжүүлсэн гүйлгээний дүнг цахим системийн 67 төлбөрийн баримттай тулган шалгахад 250.0 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сар бүрийн бараа, ажил үйлчилгээний гүйлгээ нэг бүрийг цахим системийн төлбөрийн баримттай тулгаж, зөрүүг залруулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд шилжүүлсэн гүйлгээний дүнг цахим системийн төлбөрийн баримттай тулган шалгахад зөрүүтэй.	1	250.0					1	250.0
Дүн		1	250.0					1	250.0